**ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН 2018 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ**

Байгууллагын нэр: **Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар**

Огноо: 2019.01.07

| Зорилт | № | Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин /тоо хэмжээ, хувь/ | Хүрсэн түвшин /хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ/ | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр /мян.төг/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.Хүний нөөцийг чадавхжуулах | 1 | Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт | Дотоод сургалтын тоо | 5-аас дээш | Байгууллага дотооддоо 9 төрлийн 252 цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 101 албан хаагчийг хамруулсан.Үүнд:<br>➢ Бүртгэл мэдээллийн /цагийн системийн танилцуулга сургалт<br>➢ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн орнууд жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийг тамхины эсрэг өдөр болгон тэмдэглэн ирсэн бөгөөд 2018 оны энэ өдрийг “Тамхи зүрхэнд хортой-Тамхийг биш эрүүл мэндээ сонгоё” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэсний дагуу тус аяны хүрээнд “Тамхины хор хөнөөл, тамхины хяналтын хуулийн хэрэгжилт” сэдэвт сургалт<br>➢ Хөдөлмөр нэгдсэн сан LMIS программын ашиглалт, хэрэглээ, үйл ажиллагааны талаар сургалт<br>➢ Нийслэл дэх Аудитын газрын дарга, доктор, профессор С.Энхбаатар албан хаагчдад зориулан “Манлайллын менежмент” сэдэвт сургалт<br>➢ Нурууны өвдөлтийн хөдөлгөөн заслын эмчилгээ, физиологийн мурийлт, багана | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2.600.000 | 1.Албан хаагчдыг чадавхжуулах 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын 2018 оны А/29 дүгээр тушаалын дагуу “Хөдөлмөрийн эдийн засаг ба социологи” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад шаардагдах 2.600.000 төгрөгийг батлагдсан төсвийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас гаргасан.<br>2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн холбогдох зардлаар “Сантис” сургалтын төвтэй хамтран албан хаагчийг англи |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нурууны ачаалал, тэдгээрээс урьдчилан сэргийлэх талаар албан хаагчдад зориулсан мэдээлэл, зөвлөгөө<br>➢ Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургуультай хамтран Хөдөлмөрийн эдийн засаг ба социологи” ерөнхий сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж, албан хаагчдад мэдээлэл өгсөн.<br>➢ Албан хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Сантис” сургалтын төвтэй хамтран 6 албан хаагчийг англи хэлний сургалтад хамруулж, сертификат олгуулсан.<br>➢ Мирай шүдний эмнэлэгтэй хамтран амны хөндийн эрүүл мэнд, шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нь сэдвээр албан хаагчдад мэдээлэл өгсөн.<br>➢ Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн холбогдох заалтуудаар 2018.11.05-ны өдөр хаагчдад сургалт зохион байгуулсан. Сургалтаар хуулийн шинэчилсэн төсөлд орсон онцлог зохицуулалтын талаар мэдээлэл өгсөн.<br>100% | | хэлний сургалтад хамруулах 6.000.000 төгрөгийн гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тайлант хугацаанд 6 албан хаагчийг сургалтад хамруулсан бөгөөд 2019 онд үлдсэн санхүүжилтээр албан хаагчдыг сургана. |
| | | | Албан хаагчдын хамрагдсан байдал | 80 хувиас дээш | Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх дотоодын сургалтад давхардсан тоогоор албан хаагчдын 90-ээс дээш хувь хамрагдсан.<br>100% | | |
| | | | Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан | 20 хувиас дээш | 1.ХБНГУ-д зохион байгуулагдсан сургалт, туршлага солилцох уулзалтад Сургалт судалгааны хэлтсийн дарга С.Нямдорж оролцлоо. | 1.Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн | 1.Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байдал | | 2.Бүгд Найрамдах Ирланд улсад туршлага солилцох уулзалтад Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Гантүшиг оролцсон.<br>3. Европын Холбооны Улсын төсвөөр Латви, Литва улсад Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн Газрын дарга П.Батхүлэг сургалтад оролцсон.<br>4. Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Берлин хотод зохион байгуулагдсан туршлага солилцох уулзалтад Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн Газрын дарга П.Батхүлэг оролцсон.<br>5.Бүгд Найрамдах Турк улсад Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн Газрын дарга П.Батхүлэг албан томилолтоор ажилласан.<br>100% | санхүүжилтээр<br>2. Европын холбооны Монголд хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд “Secim” олон улсын байгууллагын санхүүжилтээр<br>3. Европын холбооны Монголд хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд “Secim” олон улсын байгууллагын санхүүжилтээр<br>4. Нэг өрх-Нэг ажлын байр хөтөлбөрийн санхүүжилтээр<br>5.ХХҮЕГ-ын санхүүжилтээр | төслийн шугамаар ХБНГУ-д 2018.06.21-07.01-ний өдрүүдэд зохион байгуулагдсан.<br>2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох албан тушаалтнуудын хамт 2018.09.10-09.18-ны өдрүүдэд оролцсон.<br>3. ХХҮЕГ-ын даргын 2018 оны А/182 дугаар тушаалын дагуу 2018.08.18-27-ны өдрүүдэд оролцсон.<br>4. Нийслэлийн Засаг даргын 2018.11.15-ны өдрийн А/1066-р захирамжаар Нэг өрх-Нэг ажлын байр хөтөлбөрийн хүрээнд 2018.12.06-12.17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.<br>5.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох зорилгоор 2018.12.31-2019.01.05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. |
| | 2 | Мэргэшсэн туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх | 3 болон түүнээс дээш жил ажилласан | 70 хувиас дээш | Нийт албан хаагчдын 80 хувь нь 3 болон түүнээс дээш ажилласан, мэргэшсэн туршлагатай боловсон хүчнүүд байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | | мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт | | 90% | | |
| **Хэсгийн дундаж: 97.5 %** | | | | | | | |
| 2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | 3 | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо | Гүйцэтгэлээр | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний салбарын ажилтны өдрийг тохиолдуулан ХХҮЕГ-ын даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр Ахлах мэргэжилтэн С.Нарантуяа, ажилтан О.Гэрэлцогт, Нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр Мэргэжилтэн Т.Одонтогоо, Г.Долгорсүрэн, С.Угантуяа нар шагнагдсан.<br>Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 379 жилийн ойн баярыг тохиолдуулан Нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр мэргэжилтэн мэргэжилтэн Б.Сайнжаргал шагнагдсан.<br>Мөн 2018 оны шинэ жилийн баярыг тохиолдуулан ажил хөдөлмөрийн өндөр амжилт гарган хамт олноо манлайлан ажилласан Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Г.Ганзориг, Сургалт, судалгааны хэлтсийн дарга С.Нямдорж, хөтөлбөрийн ажилтан О.Гэрэлцогт нар ХНХЯ-ны “Жуух” бичгээр, мэргэжилтэн Л.Норов ХХҮЕГ-ын даргын “Хүндэт өргөмжлөл”өөр, мэргэжилтэн О.Оюунгэрэл, Д.Гэрэлцэцэг нар МЗХ-ны “Тэргүүний залуу” цол тэмдгээр тус тус шагнагдсан.<br>100% | | |
| | | | Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан | Гүйцэтгэлээр | УИХ-ын 2017 оны “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлалсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 29 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах | | дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажиллалаа. 70% | | |
| | 4 | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга | Сэтгэл ханамж 80 хувиас дээш | Байгууллагын албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг ханган ажиллаж байна. Ажлын байрны таатай орчныг ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаагаар 85-аас дээш хувьтай байна. 85% | | |
| | | | Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх | Гүйцэтгэлээр | Албан хаагчид сар бүрийн үндсэн цалин дээр унаа хоолны нэмэгдлийг авч байна. 100% | | |
| | 5 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг | Жилд 1-ээс доошгүй удаа | Албан хаагчдыг элэгний B, C вирусийн шинжилгээ, оношилгоонд хамруулж, "Евростандарт "клиниктэй хамтран ажиллалаа. Биеийн тамирыг хүн амын өдөр тутмын хэрэглээ болгох, дундаж наслалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд албан хаагчдад архи, тамхи, мансууруулах бодис түүнээс урьдчилан сэргийлэх талаар албан хаагчдад яриа таниулга, сурталчилгаа хийв. Мөн Нийслэлийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Мөнгөн Улаанбаатар-2018” өвлийн спорт наадамд байгууллагаараа идэвхтэй оролцсон ба Байгууллагын ажилтан, албан хаагчдын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг авч, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгнэлээ.<br>АШУҮИС-иас Нурууны өвдөлтийн хөдөлгөөн заслын эмчилгээ, физиологийн муруйлт, багана нурууны ачаалал, тэдгээрээс урьдчилан сэргийлэх талаар албан хаагчдад мэдээлэл, зөвлөгөө өглөө.<br>Мирай шүдний эмнэлгээс албан хаагчдад зориулж шүдний эрүүл мэндийн талаар мэдээлэл өгч, анхан шатны үзлэг, оношилгоо хийсэн.<br>100% | | |
| | | | Албан хаагчдын хамрагдалт | 100 хувь | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээнд албан хаагчид 90 хувь оролцсон.<br>85% | | |
| **Хэсгийн дундаж: 90 %** | | | | | | | |
| **Үнэлгээний дундаж хувь: 93.75%** | | | | | | | |